



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

᠒᠐᠐7 оны ᠐8 сарын ᠐8 өдөр

Дугаар ᠒᠑᠒

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах, тушаалд
өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”, Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагуудын санал, “Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлаар санал боловсруулах зөвлөл”-ийн 2007 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, “МИАТ” ХК хооронд 2006 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ, Гадаадын их, дээд сургуульд улсын зардлаар магистрантурт суралцах эрхийн бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баттөмөр овогтой Энхбаярыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар АНУ-ын Хойд Вирджинийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Цэрэндорж овогтой Мөнхболдыг Үндэсний статистикийн газрын захиалгаар АНУ-ын Stratford их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Ванчигсүрэн овогтой Энхтамирыг Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Австрали улсын Deakin их сургуулийн магистрантурт хуулийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Бибиш овогтой Оюун-Эрдэнийг Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар АНУ-ын Stratford их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Жүгдэр овогтой Мөнхбаатарыг Батлан хамгаалах яамны захиалгаар АНУ-ын Stratford их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Дашпунцаг овогтой Хишигжаргалыг Хүнс, хөдөө аж ахуйн яамны захиалгаар АНУ-ын Ютагийн Улсын их сургуулийн магистрантурт хүнсний аюулгүй байдлын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Батсүх овогтой Бархасбадийг Байгаль орчны яамны захиалгаар Англи улсын Лондонгийн Бизнес, санхүүгийн сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Сандаг-Очир овогтой Нямсүрэнг Түлш, эрчим хүчний яамны захиалгаар Англи улсын Лондонгийн Удирдлагын сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

᠒᠐ ᠒᠑᠑᠖

2. Жамъянсүрэн овогтой Болормааг АНУ-ын Миннесотагийн их сургуулийн докторантурт эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Сүхбаатар овогтой Эрдэнэболдыг АНУ-ын Индиана их сургуулийн магистрантурт хуулийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

3. Баяр овогтой Энхмааг Англи улсын Лондонгийн Оксфорд коллежид санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Пүрэвдорж овогтой Нансалыг АНУ-ын Columbia коллежид бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Галбаатар овогтой Мишээлийг ХБНГУ-ын Бонн хотын их сургуульд социологийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Батбаяр овогтой Энхтайваныг Канад улсын British Columbia технологийн институтэд онгоцны засвар үйлчилгээний инженерийн ангид 2 жилийн хугацаагаар тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

4. Итали улсын Ром хотын Тор Вергата их сургуулийн докторантурт анагаах ухааны чиглэлээр суралцаж буй Цэвэгмид овогтой Эрдэмбилэгийн суралцах хугацааг 1 жилээр сунгасугай.

5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 185 дугаар тушаалын "Англи улсын Холборн коллежийн магистрантурт эрх зүйн чиглэлээр" гэснийг "АНУ-ын Хойд Вирджинийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр" гэж өөрчилсүгэй.

6. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



САЙД

Ө.Энхтүвшин

Ө.ЭНХТҮВШИН